## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2018 ОНЫ 170 ДУГААР ТУШААЛААР БАТЛАГДСАН 2018-2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ "ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЭХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*2020 оны эхний хагас жилийн байдлаар*

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хариуцах байгууллага | Хугацаа | Төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх** | | | | | | |
| 1.1. | Иргэний нисэхийн тухай хууль болон иргэний нисэхийн багц дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулж ерөнхий зориулалтын нисэхийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох. | 1.1.1. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад дараах зохицуулалтыг тусгах, үүнд:<br>- Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, зөвшөөрөл олгох талаар;<br>- Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлага;<br>- Ерөнхий зориулалтын нисэхийн болон агаарын тээврийн хөгжлийг дэмжих Нисэхийн хөгжлийн сан байгуулах. | Иргэний нисэхийн тухай хуульд тусгаж хэрэгжүүлэх | ЗТХЯ ИНЕГ | 2018-2019 он | - Иргэний нисэхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, зөвшөөрөл олгох талаар 10 дугаар зүйл, 10.1 дэх, 10.1.1 дэх, 10.1.2 дахь, 10.1.3 дахь, 10.1.4 дэх, 10.1.5 дахь,10.1.9 дэх, 10.1.10 дахь, 20.1 дэх, 20.2 дахь, 20.3 дахь, 20.4 дэх,<br>- Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, хариуцлагыг 3.1 дэх, 5.1.25 дахь, 8.2 дахь, 8.2.1 дэх, 8.2.1.2 дахь, 8.2.1.3 дахь, 8.2.1.4 дэх, 8.2.1.5 дахь, 8.2.2 дахь, 8.2.2.1 дэх, 8.2.2.2 дахь, 8.2.2.3 дахь, 24.1 дахь, 24.2 дахь, 24.3 дахь, 24.4 дэх, 24.5 дахь, 24.6 дахь, 26 дахь, 26.1 дэх, 26.1.1 дэх, 26.1.2 дахь, 26.2 дахь, 26.3 дахь, 26.4 дэх,<br>- Ерөнхий зориулалтын нисэхийн болон агаарын тээврийн хөгжлийг дэмжих Нисэхийн хөгжлийн сан байгуулах асуудлыг 25 дугаар зүйл, 25.1 дэх, 25.2 дахь, 35.6 дахь, 42.1 дэх, 42.1.1 дэх, 42.1.2 дахь, 42.1.3 дахь, 42.1.4 дэх, 42.1.6 дахь, 42.1.7 дахь, 42.1.8 дахь, 42.2 дахь заалтууд тус тус орсон.<br>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад дараах саналуудыг Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 43 дугаар зүйлийн 43.3-т Нутгийн захиргааны байгууллага нь Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналаар гурван мянгаас дээш байнгын оршин суугчтай суурин газарт аэродром, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ерөнхий зориулалтын нисэхийн зурвас, талбай байгуулах газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах гэж оруулсан боловч батлагдаагүй байна. Үүнд: -Ерөнхий зориулалтын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тодорхойлон, хувь хүн болон нисгэгчийн үүрэг хариуцлагын талаар Иргэний нисэхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төсөлд тусгах саналыг Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчдэд 2018 оны 08-р сарын 29-ны өдрийн 01/2870 тоот албан бичгээр хүргүүлж ирсэн саналуудыг нэгтгэн 2019 оны 01 дүгээр улиралд Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ажлын хэсгийн гишүүнд цахим хаягаар хүргүүлж, хуулийн төсөлд тусгасан **/Хэрэгжилт 70 %/** |
| | | 1.1.2. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагааг зохицуулах иргэний нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, шаардлагатай дүрмийг шинээр боловсруулах. **/ЗГҮАХХАХТ-2.115.(2)/** | Иргэний нисэхийн багц дүрмийн зохицуулалт бүрдэж хэрэгжих | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | ИНД-Бага оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх 101, 103, 104, 105, 106, 21, 39, 43, 61, 66, 67, 139, 149, 71, 77 дүрмүүдийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 187 дугаар тушаалаар батлуулж, улсын бүртгэлийн 1444-т бүртгүүлсэн. **/Хэрэгжилт 70%/** |
| 1.2. | Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, үнэмлэхжүүлэх, нислэгийн захиалга, төлөвлөлтийг хялбаршуулах, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний дүрэм, журмыг боловсронгүй болгох | 1.2.1. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох шаардлагыг тогтоох, хялбаршуулах **/ЗГҮАХХАХТ-2.115.(2)/** | Зохицуулалтыг хялбаршуулах, боловсронгүй болгох | ЗТХЯ ИНЕГ | 2018-2019 он | Иргэний нисэхийн тухай хуулийн төсөлд ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, зөвшөөрөл олгох талаар 20.1, 20.2, 20.3, 20.4 дэх заалт тусгасан. “Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам”-д хэт хөнгөн агаарын хөлөг хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэхэд нислэгийн зөвшөөрөл олгохгүй байхаар 2018 оны 10 дугаар сарын 15-ны А/654 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан. Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журмын төслийг боловсруулан ажиллаж байна. Тус журмын төсөлд 5700 кг-аас доош жинтэй агаарын хөлөг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэхэд нислэгийн зөвшөөрөл олгохгүй байхаар зохицуулалт хийхээр төлөвлөн ажиллаж байна.<br><br>Ерөнхий зориулалтын нисэхийн эрх зүйн зохицуулалтын боловсронгүй ажлын хүрээнд Иргэний нисэхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төсөлд ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, зөвшөөрөл олгох талаар ажлын хэсэгт хүргүүлж, 20.1 дэх, 20.2 дахь, 20.3 дахь, 20.4 дэх заалтууд ту тус орсон.<br><br>**/Хэрэгжилт 30%/** |
| | | 1.2.2 Бага оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хялбаршуулах **/ЗГҮАХХАХТ-2.115.(2)/** | Хяналтыг хялбаршуулах, боловсронгүй болгох | ИНЕГ | 2018-2019 он | Иргэний нисэхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төслийн 42.1.1 дэх, 42.1.2 дахь, 42.1.3 дахь, 42.1.4 дэх, 42.1.6 дахь, 42.1.7 дахь, 42.1.8 дахь, 42.2 дахь, 25 дугаар зүйл, 25.1 дэх, 25.2 дахь заалтыг тусгагсан.<br>**/Хэрэгжилт 30 %/** |
| | | 1.2.3. Ерөнхий зориулалтын нислэгийн хөдөлгөөний мэдээлэл, зохицуулалтын нэгж байгуулж, нислэгийн захиалга, төлөвлөлтийг хялбаршуулах | Мэдээлэл, зохицуулалтын нэгж байгуулах | ИНЕГ | 2018-2022 он | Нислэгийн зөвшөөрлийг утсаар өгөх туршилтыг 2018 онд амжилттай турших хэрэгжүүлсэн. Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журмын төсөлд мэдээлэл зохицуулалтын нэгж байгуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Уг журмын төслийг батлуулах шатанд байна.<br><br>**/Хэрэгжилт 30%/** |
| | | 1.2.4. “Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журам”-д шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний дүрэм, журмыг сайжруулах | Зохицуулалтыг боловсронгүй болгох | ИНЕГ | 2018-2019 он | Журмын төслийг боловсруулж, санал авахаар Нислэгийн урсгал төлөвлөлтийн алба, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Монголын Иргэний агаарын тээврийн нисгэгчдийн холбоонд хүргүүлээд байна.<br>**/Хэрэгжилт 30%/** |
| 1.3. | Холбогдох төрийн байгууллага болон ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, бусад оролцогчийн | 1.3.1. Нислэгийн үйл ажиллагааны төрлөөс хамаарч оролцогч талуудын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны хангалтын шаардлага, эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох судалгаа хийх | Аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тодорхойлох | ИНЕГ | 2018-2021 он | Ерөнхий зориулалтын нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тодорхойлон, хувь хүн болон нисгэчийн үүрэг хариуцлагын талаар судалгаа хийж, санал, дүгнэлт гарган Иргэний нисэхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төсөлд саналаа хүргүүлсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны шаардлага, эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох | | | | | **/Хэрэгжилт 70%/** |
| | | 1.3.2. Нислэгийн үйл ажиллагаанд оролцогч талуудын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны хяналт шаардлагыг тогтоох, үйл ажиллагааны журам, зааварт тусгах | Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих | ИНЕГ | 2018-2022 он | Иргэний нисэхийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-ын төсөлд 3.1 дэх, 5.1.25 дахь, 8.2 дахь, 8.2.1 дэх, 8.2.1.2 дахь, 8.2.1.3 дахь, 8.2.1.4 дэх, 8.2.1.5 дахь, 8.2.2 дахь, 8.2.2.1 дэх, 8.2.2.2 дахь, 8.2.2.3 дахь, 10 дугаар зүйл, 10.1 дэх, 10.1.1 дэх, 10.1.2 дахь, 10.1.3 дахь, 10.1.4 дэх, 10.1.5 дахь,10.1.9 дэх, 10.1.10 дахь, 24.1 дахь, 24.2 дахь, 24.3 дахь, 24.4 дэх, 24.5 дахь, 24.6 дахь, 25 дугаар зүйл, 25.1 дэх, 25.2 дахь, 26 дахь, 26.1 дэх, 26.1.1 дэх, 26.1.2 дахь, 26.2 дахь, 26.3 дахь, 26.4 дэх заалтууд тус тус орсон.<br>**/Хэрэгжилт 70%/** |
| 1.4. | Ерөнхий зориулалтын агаарын хөлөг ашиглах төрийн байгууллага болон салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах | 1.4.1. Орон нутгийн засаг захиргаа, хөдөө аж ахуй, онцгой байдал, эрүүл мэнд, байгаль хамгаалах зэрэг чиглэлээр хамтран ажиллах хүрээг тодорхойлох **/ЗГҮАХХАХТ-2.115. (2)/** | Хамтран ашиглах зохицуулалт бүрдэж, хэрэгжих | ЗТХЯ | 2018-2022 он | Хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамдтай Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулахаар санамж бичгийн төслийг боловсруулж ЗТХЯ-нд хүргүүлсэн.<br>Улаанбаатар - Дархан чиглэлийн авто замын засварын ажил хийгдэж байгаатай холбогдуулан эрүүл мэндийн яаралтай түргэн тусламж, онцгой байдлын үед агаарын тээврийн үйлчилгээг ашиглах зорилгоор Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод байнгын үйл ажиллагаатай нислэг үйлдэх талаар Сэлэнгэ аймгийн засаг даргын тамгын газар болон ЗТХЯ, ЭМЯ хооронд санамж бичиг байгуулах болсны дагуу санамж бичгийн төслийг боловсруулж 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 01/943 албан тоотоор Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн<br>2020 оны 4 дүгээр сарын 30- ны өдөр ИНЕГ, ОБЕГ хооронд Хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах ажиллагаанд бага оврын агаарын хөлөг ашиглах, хөөрч буух |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зурвас, вертодром, шатахуун хангамж, ангар барих газрын төлөвлөлт, байршлыг тогтоож, агаараас эрэн хайх, аврах нэгж байгуулах нөхцөлийг бүрдүүлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, зайнаас тандан судлах ажиллагаанд хүнгүй нисэх төхөөрөмж (UAS)-ийг ашиглах зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.<br>ИНЕГ болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам хооронд шууд хамтран ажиллах санамж бичиг байгуулахад эрх зүйн хувьд боломжгүй тул Зам, тээврийн хөгжлийн яам болон болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулж өгөх тухай 2019 оны 9-р сарын 12-ны өдрийн 01/3039 тоот албан бичгийг ЗТХЯ-нд хүргүүлсэн. Үүний хариуд ЗТХЯ-аас яамд хооронд санамж бичиг байгуулах шаардлагагүй гэж хариу ирүүлсэн.<br>**/Хэрэгжилт70 %/** |
| | | 1.4.2. Аялал жуулчлалын чиглэлийг нисэх буудал, ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийн төлөвлөлттэй уялдуулан төлөвлөх **/ЗГҮАХХАХТ-2.115. (2)/** | Хамтран ашиглах зохицуулалт бүрдэж хэрэгжих | ЗТХЯ | 2018-2022 он | Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулж, санамж бичиг байгуулж өгөх тухай 2019 оны 9-р сарын 12-ны өдрийн 01/3039 тоот албан бичгийг ЗТХЯ-нд хүргүүлсэн.<br>ИНЕГ болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам хооронд шууд хамтран ажиллах санамж бичиг байгуулахад эрх зүйн хувьд боломжгүй тул Зам, тээврийн хөгжлийн яам болон болон Байгаль орчин, аялал жуулчлалын яам хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулж өгөх тухай 2019 оны 9-р сарын 12-ны өдрийн 01/3039 тоот албан бичгийг ЗТХЯ-нд хүргүүлсэн. Үүний хариуд ЗТХЯ-аас яамд хооронд санамж бичиг байгуулах шаардлагагүй гэж хариу ирүүлсэн.<br>**/Хэрэгжилт 70 %/** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.4.3. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, онцгой байдлын үед ашиглах хөөрч буух зурвас, вертодром байгуулах байршлыг хамтран тогтоож, хэрэгжүүлэх **/ЗГҮАХХАХТ-2.115. (2)/** | 10-с доошгүй байршил тогтоох, байгуулах | ЗТХЯ | 2018-2022 он | Хэлипортын стандартын дагуу байгуулагдаж буй нисдэг тэрэгний тавцан<br>1. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв<br>2. Гэмтэл согог судлалын үндэсний төв<br>3. Халдварт өвчин судлалын үндэсний төв<br>4. Алтан булаг чөлөөт бүс<br>5. International school<br>6. Success rider building (дээвэр)<br>7. Сити товер (дээвэр)<br>8. Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг<br>**/Хэрэгжилт 70%/** |
| 1.5. | Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэхэд түрээс, хөнгөлөлттэй зээл зэрэг санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх | 1.5.1. Агаарын хөлгийн бүртгэлтэй уялдуулж ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх түрээс, хөнгөлөлттэй зээл зэрэг санхүүгийн бүтээгдэхүүн бий болгох **/ТИНСББХАХТ-4.1/** | Агаарын хөлөг барьцаалан зээл авах тогтолцоо бүрдэж хэрэгжих | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | МУ-ын Хөгжлийн банкны охин компани болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудад хүү бага, урт хугацаатай санхүүгийн түрээсийн үйлчилгээг үзүүлдэг ДИ БИ ЭМ лизинг компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын захирал холбогдох албан тушаалтнуудтай Ерөнхий зорилалтын агаарын тээвэрлэгчдийн холбоо, хувийн хэвшлийнхэний төлөөллийг оролцуулан хамтарсан уулзалт танилцуулга 2020 оны 4 дүгээр сарын 8-нд зохион байгуулж дэмжлэг авах шийдэлд хүрсэн. Тус санхүүгийн байгууллагатай хамтран Ерөнхий зориулалтын агаарын хөлөг болон энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх хамтарсан тооцоо судалгааг боловсруулж байна.<br>**/Хэрэгжилт 30%/** |
| | | 1.5.2. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийг сургалтын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс түрээсээр авч ашиглах зохицуулалт бүрдүүлэх | Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | Ерөнхий зориулалтын нисэхийн албанаас Буянт-Ухаа дахь нисэх буудлын зохих хэсгийг цаашид бага оврын агаарын хөлгийн засвар үйлчилгээ, нисэхийн сургалтын төв байгуулах тооцоо судалгааг дахин нарийвчлан боловсруулж хэрэгжилтийг эхлүүлэх үүднээс шаардлагатай зай талбайн мэдээллийг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ИНҮТ-ийн Төсөл, хөтөлбөрийн тасагт хүргүүлсэн бөгөөд ИНҮТ-ийн Төсөл, хөтөлбөрийн тасгаас "Буянт-Ухаа дахь олон улсын нисэх буудлын цаашдын ашиглалтын төлөвлөгөө"-г нарийвчлан боловсруулж батлуулахаар Иргэний |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нисэхийн Ерөнхий Газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 01/719 тоот албан бичгээр Зам, Тээврийн Хөгжлийн яаманд хүргүүлсэн. Одоогийн байдлаар батлагдаж ирээгүй байна. **/Хэрэгжилт 70%/** |
| 1.6. | Иргэд хувийн хэрэгцээндээ зориулан агаарын хөлөг, нисдэг тэрэг авч ашиглахад татварын дэмжлэг үзүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх | 1.6.1. Дэлхийн худалдааны байгууллагын "Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр"-т нэгдэн орж, олон улсын зохицуулалт бүрдүүлэх **/ТИНСББХАХТ-4.5/** | Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих | ЗТХЯ | 2018-2021 он | Монгол улсын хуулиар Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээрт хэлэлцээрт 2018 оны 10 сарын 12-ны өдөр нэгдэн орсон. **/Хэрэгжилт 100%/** |
| | | 1.6.2. "Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр"-т дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, зохицуулалтыг бүрдүүлэх **/ТИНСББХАХТ-4.5/** | Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих | ЗТХЯ ИНЕГ | 2018-2021 он | Гаалийн тариф татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай санал хүргүүлсэн бөгөөд "Гаалийн тариф, гаалийн татварын тухай" хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9.-д Иргэний агаарын бүх хөлөг болон хөдөлгүүр, тэдгээрийн бүх эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, 38.1.9.-д газар дээрх нислэгийн бүх дадлагажуулур болон түүний эд анги, бүрэлдэхүүн хэсэг гэж тусгасан. **/Хэрэгжилт 70%/** |
| 1.7. | Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах газрын хэмжээ, байршлыг орон нутгийн эрх бүхий байгууллагатай хамтран тогтоож, газрын төлбөрийн хэмжээг бууруулах, чөлөөлөх зохицуулалтыг судлан шийдвэрлүүлэх | 1.7.1. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах аэродромын газрын хэмжээ, байршлыг орон нутгийн засаг захиргаатай хамтран тогтоож, аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгах **/ЗГҮАХХАХТ-5.2.4 (2)/** | Хөөрч, буух 116 зурвас, шатахуун хангамжийн 30 төв байгуулах байршлыг тогтоох, баталгаажуулах | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын Даргын 2019 оны 8 дугаар сарын 21-ний А/677 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд 2020-2022 оны хооронд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. Тус дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу аймаг орон нутагт хэрэгжүүлэхээр ИНЕГ-ын төсөвт 12 хөөрч буух зурвас болон 3 шатахуун хангамжийн төв байгуулахаар нийт 580 сая төгрөг төсөвлөсөн боловч дэлхий нийтийг хамарсан Covid 19 өвчний тархалтын улмаас Монгол Улсын эдийн засгийн хувьд хүндрэл үүсэх эрсдэлээс сэргийлж ИНЕГ-ын даргын 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/205 тушаалаар батлагдсан Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллуулах тухай тушаалын дагуу 2021 он хүртэл санхүүжилтийг хойшлуулсан. **/Хэрэгжилт 70%/** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.7.2. Ерөнхий зориулалтын нисэхт ашиглах газрын суурь үнэлгээг тогтоох, газрын төлбөрийг бууруулах, чөлөөлөх талаар холбогдох хууль тогтоомжид тусгах **/ЗГҮАХХАХТ-5.2.4 (2)/ /ТИНСББХАХТ-4.5/** | Газрын төлбөрийн зохицуулалт бүрдэж хэрэгжиж | ЗТХЯ ИНЕГ | 2018-2021 он | Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрыг тусгай хэрэгцээнд авах гаргах журмын төслийн шинэчилсэн найруулгад тус тус саналаа ЗТХЯ-нд цахим хэлбэрээр хүргүүлсэн. Тус саналд:<br><br>10 дугаар зүйл. Хот, тосгон, бусад суурин, үйлдвэрлэл, дэд бүтцийн газар. Дэд бүтцийн газарт агаарын навигацийн байгууламж, аэродром, вертодром, нисэх буудал гэж нэмж оруулах<br><br>- 129 дүгээр зүйл. Зам, шугам сүлжээний газрыг зохистой ашиглах заалтад аэродром, нисэх буудал, аэродромын барилга байгууламжтай холбоотой заалт оруулах<br><br>- 87. дугаар зүйл. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө 7.2.8. шинээр баригдах улс хоорондын болон улс, бүс нутгийн ач холбогдолтой төмөр зам, авто замын болон эрчим хүч дамжуулах, харилцаа холбооны шугам сүлжээ, барилга байгууламж байгуулах газрын схемчилсэн байршил, хэмжээ, хил зааг; гэсэн заалтад , "аэродром, вертодром, нисэх буудал" гэж нэмж оруулах.<br><br>47.1.2.10.аэродром, вертодром, нисэх буудлын барилга байгууламж гэсэн заалт нэмж оруулах<br><br>**• Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам"-д өөрчлөлт оруулах тухай засгийн газрын тогтоолын төсөлтэй танилцаж санал боловсруулж ЗТХЯ-нд цахимаар 2020 оны 4 дүгээр сарын 28-д-нд цахимаар хүргүүлсэн. Үүнд:** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Нэг. 1.2. Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, тусгай хэрэгцээнээс гаргах (цаашид "газрыг тусгай хэрэгцээнд авах, гаргах" гэх) санал боловсруулах үйл ажиллагаанд энэхүү журам болон Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Монгол Улсын хилийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Хог хаягдлын тухай хууль холбогдох бусад хууль, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журмыг дагаж мөрдөнө. Иргэний нисэхийн тухай хууль нэмж оруулах<br><br>-Уг журмын 5.4 т заасан Тусгай горим, дэглэм бүхий улсын тусгай хэрэгцээний газарт энэхүү журмын 5.3-т заасны дагуу газар ашиглуулах шийдвэр гаргахдаа тухайн газарт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн байгууллагын саналыг заавал авсан байна гэсэн заалтыг хэвээр үлдээх<br><br>2.1.14. Иргэний нисэхийн хуулийн 20.1-д заасан Нислэгийн аюулгүй ажиллагааг хангах шаардлагын үүднээс иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага харъяалах сум, дүүргийн Засаг даргатай хамтарч аэродром орчмын аюулгүйн бүсийг тогтоосон байна<br><br>Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр 2018-2022 онд хэрэгжүүлнэ гэсэн заалт байгаа. Хэрэв энэхүү журмын 6. Газрыг улсын тусгай хэрэгцээнээс гаргах үйл ажиллагаа. 6.3.4. 2.1.13-д заасан зориулалт буюу үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжиж дууссан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиолдолд газрыг тусгай хэрэгцээнээс гаргана гэсэн байна.<br>Энэхүү заалтыг өөрчлөн Тусгай хэрэгцээнээс гаргах тохиолдолд тухайн газрыг орон удидрлага болон тус газрыг ашиглаж байсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тусгай хэрэгцээнээс гаргах<br>Мөн Газрын төлбөрийн тухай хуульд ерөнхий зориулалтын чиглэлээр ашиглаж буй газрыг төлбөрөөс чөлөөлөх, тусгай хэрэгцээнд авах санал оруулахаар тандан судалгаа боловсруулж байна.<br>**/Хэрэгжилт 70%/** |
| | | 1.7.3. Газрын суурь үнэлгээг тогтоох шаардлагатай баримт бичиг боловсруулах, судалгаа хийх. **/ЗГҮАХХАХТ-5.2.4 (2)/** | Газрын төлөвлөлт тодорхой болох | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | ЗТХ сайд 21 аймгийн засаг дарга нартай 2019 оны 1 дүгээр сарын 17-нд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний<br>- 4.5.1. "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 3.2.5 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтран шаардлагатай сумуудад Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасыг сонгон Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтын дагуу орон нутгийн тусгай хэрэгцээний газарт авах;<br>- 4.5.2. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурваст хариуцагч томилон, байнгын арчлалт, хамгаалалт хийхэд гаргах зардлыг аймгийн төсөвт суулгахаар тусгагдсан.<br>**/Хэрэгжилт 30%/** |
| 1.8. | Ерөнхий зориулалтын агаарын хөлгөөр алслагдсан сум, суурин газарт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгох | 1.8.1. Алслагдсан сум, суурин газарт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх "Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр" боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх **/ЗГҮАХХАХТ-2.114. (2)/** | Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих | ЗТХЯ | 2018-2022 он | "Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр" Монгол Улсын засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 283 дугаар тогтоолоор батлагдсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна.<br>**/Хэрэгжилт 70%/** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1.8.2. Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ үзүүлэхэд тохиромжтой агаарын хөлгийн судалгаа хийж, техник, эдийн засгийн үр ашгийн боломжийг тодорхойлох. | Судалгаа хийж тодорхойлох | ИНЕГ | 2018-2022 он | Хөдөө орон нутаг, алслагдсан аймаг сумдад агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай агаарын хөлгийн судалгааг хийсэн бөгөөд ATR-72, Cessna Grand Caravan 208 агарын хөлгүүд тохиромжтой гэсэн санал дүгнэлт гарч эдийн засгийн тооцоолол, үзүүлэлтийг гарган удирдлагад танилцуулсан. **/Хэрэгжилт 70%/** |
| **Зорилт 2. Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх** | | | | | | |
| 2.1. | Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг ашиглалтад оруулж, “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг нүүлгэн шилжүүлсний дараа одоогийн нисэх буудлын барилга байгууламжийн зохих хэсгийг ерөнхий зориулалтын нисэхийн төв болгон өөрчлөн зохион байгуулах | 2.1.1. Барилга байгууламжийн зохих хэсгийг агаарын хөлгийн засвар үйлчилгээ, сургалтын чиглэлээр ашиглах ерөнхий зориулалтын нисэхийн төв болгон зохион байгуулах | Ерөнхий зориулалтын нисэхийн төв байгуулах | ИНЕГ ЕЗНХА | 2018-2021 он | Ерөнхий зориулалтын нисэхийн албанаас Буянт-Ухаа дахь нисэх буудлын зохих хэсгийг цаашид бага оврын агаарын хөлгийн засвар үйлчилгээ, нисэхийн сургалтын төв байгуулах тооцоо судалгааг дахин нарийвчлан боловсруулж хэрэгжилтийг эхлүүлэх үүднээс шаардлагатай зай талбайн мэдээллийг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ИНҮТ-ийн Төсөл, хөтөлбөрийн тасагт хүргүүлсэн бөгөөд ИНҮТ-ийн Төсөл, хөтөлбөрийн тасгаас “Буянт-Ухаа дахь олон улсын нисэх буудлын цаашдын ашиглалтын төлөвлөгөө”-г нарийвчлан боловсруулж батлуулахаар Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 01/719 тоот албан бичгээр Зам, Тээврийн Хөгжлийн яаманд хүргүүлсэн. **/Хэрэгжилт 70%/** |
| 2.2. | Орон нутаг дахь ашиглагдахгүй болсон нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурвас, талбайг сэргээн сайжруулж, ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах | 2.2.1. Улсын төсвийн болон орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар тухайн орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, аялал жуулчлал, уул уурхай зэрэг салбарын хөгжилтэй уялдуулан нисэх буудал, хөөрч, буух зурвас, талбайг сэргээн сайжруулах **/ЗГҮАХХАХТ-4.4.2. (1)/** | Хөөрч, буух 116 зурвас байгуулах, үйл ажиллагааг тогтворжуулах | ИНЕГ | 2018-2022 он | Сэлэнгэ аймаг өөрийн нөөц хөрөнгөөр бага оврын агаарын хөлөг хөөрч буух зурвас, хашаа хамгаалалт, холбоо навигацийн тоног төхөөрөмж авах ажлыг зохион байгуулж байна. ЗТХ сайд 21 аймгийн засаг дарга нартай 2019 оны 1 дүгээр сарын 17-нд байгуулсан хамтын ажиллагааны гэрээнд<br>- 4.5.1. “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 3.2.5 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Иргэний нисэхийн ерөнхий газартай хамтран шаардлагатай сумуудад Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурвасыг сонгон Газрын тухай хуулийн 16 дугаар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зүйлийн 16.1.3 дахь заалтын дагуу орон нутгийн тусгай хэрэгцээний газарт авах;<br>- 4.5.2. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын хөлөг хөөрч, буух түр зурваст хариуцагч томилон, байнгын арчлалт, хамгаалалт хийхэд гаргах зардлыг аймгийн төсөвт суулгах талаар тусгасан.<br>**/Хэрэгжилт 30%** |
| | | 2.2.2. Сэргээн сайжруулсан нисэх буудал, агаарын хөлөг хөөрч буух зурвас, талбайн засвар арчлалт, ашиглалтыг орон нутгийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгүүлэх тогтолцоо бүрдүүлэх | | | 2018-2022 он | 2019 онд Булган аймгийн Хутаг өндөр суманд хувийн хөрөнгө оруулалтаар бага оврын агаарын хөлөг хөөрч буух зурвас барьж байгуулсан.<br>Орон нутагт хуучин ашиглагдаж зурвас талбайг сэргээн сайжруулах, шинээр бага оврын агаарын хөлгийн зурвас талбай байгуулахаар 2020 оны ИНЕГ-ын төсөвт 20 аэродром байгуулахаар нийт 340 сая төгрөг төсөвлөсөн байсан боловч үүсэд буй нөхцөл байдлын улмаас хэмнэлтийн горимд шилжсэний дагуу түр хойшлуулах шийдвэр гарсан. Аймаг орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд нийтдээ 19 байршилд бага оврын агаарын хөлөг хөөрч буух зурвас талбайг сонгож орон нутгийн төсөв хөрөнгөөр байгуулах ажлыг эхлүүлээд байна. Үүнд:<br>- *Архангай аймгийн Булган, Цэнхэр*<br>- *Дархан-Уул аймгийн Дархан хот*<br>- *Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот, Алтанбулаг (чөлөөт бүс)*<br>- *Баянхонгор аймгийн Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан*<br>- *Говь-Алтай аймгийн Алтай, Бугат*<br>- *Хэнтий аймгийн Дадал, Галшар*<br>- *Сүхбаатар аймгийн Их-Өлгий*<br>- *Дорнод аймгийн Халхгол, Матад*<br>Замын-Үүд, Сайншанд, Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Хэнтий аймгийн Дэлүүнболдог болон Эрдэнэт хотод Нисэх буудал байгуулах судалгаа, Эдийн засгийн дүгнэлт шинжилгээ хийж санал дүгнэлт боловсруулан удирдлагад |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулсан бөгөөд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу тайлбар дүгнэлт оруулан бэлтгэж Зам, Тээврийн Хөгжлийн Яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна. **/Хэрэгжилт 30%/** |
| | | 2.2.3. Орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар ангарын барилга байгууламж, шатахуун хангамжийн төв барих, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх. **/ЗГҮАХХАХТ-2.115. (3)/** | Шатахуун хангамжийн 30 төв байгуулах, үйл ажиллагааг тогтворжуулах | | 2018-2022 он | *2020 оны төсвийн саналд нийт 12 нэгж төв байгуулах төсвийн санал хүргүүлсэн.* Тус ажлын хүрээнд 2020 онд өртөөчилсөн байдлаар Булган аймгийн нисэх буудал болон Хөвсгөл аймгийн нисэх буудлуудад бага оврын агаарын хөлөгт өргөн хэрэглэгддэг Авгаз шатахуун түгээх төв байгуулахаар ИНЕГ-ын төсөвт 240 төгрөг төсөвлөсөн боловч үүсээд буй нөхцөл байдлын улмаас хэмнэлтийн горимд шилжсэний дагуу түр хойшлуулах шийдвэр гарсан. 2020 онд байгуулах боломжгүй болсон. **/Хэрэгжилт 30%/** |
| 2.3. | Барилга байгууламжийн дээвэр, хот суурин газрын талбайд вертодром байгуулах, ашиглах үйл ажиллагааны норм, стандартыг баталж, хэрэгжүүлэх | 2.3.1. Вертодром байгуулах, ашиглах, үйл ажиллагааны стандарт, шаардлагыг тогтоох **/ЗГҮАХХАХТ-2.115 (2/ /ТИНСББХАХТ-8.2/** | Стандарт, норм боловсруулах, батлуулах | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | **Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 44 дугаартай тушаалаар батлагдсан Хэлипортод тавих. Ерөнхий шаардлага MNS6784:2019** стандартын дагуу 2020 онд байгуулагдаж буй нисдэг тэрэгний тавцан, талбайд үзлэг шалгалт хийж мэргэжлийн заавар зөвлөгөө өгч ажиллаж байна.<br>Үүнд:<br>- Улаанбаатар хотын шинэ захиргааны байгууламжийн ойролцоо байгуулах нисдэг тэрэгний хөөрч буух талбай<br>- Эх хүүхдийн эрүүл мэндийн төвд байгуулагдаж буй талбайд<br>- Гэмтэл согог судлалын үндэсний төвд байгуулагдсан талбайд<br>- International school-д байгуулагдаж буй талбайд<br>- Үндэсний олимпын хорооны хажууд байрлах оффисын зориулалттай баригдаж буй байшингийн дээвэр дээр байгуулагдаж буй нисдэг тэрэгний тавцанд тус тус үзлэг шалгалт хийж шаардлагатай заавар, зөвлөгөө өгч ажилласан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | /Хэрэгжилт 100%/ |
| | | 2.3.2. Ерөнхий зориулалтын нисэхийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулан батлуулах **/ЗГҮАХХАХТ-2.115 (2/** | Дэд хөтөлбөр боловсруулах хэрэгжүүлэх | ИНЕГ | 2018-2022 он | 2019 оны 8 дугаар сарын 21-ны өдрийн А/677 дугаар тушаалаар Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр батлагдсан. Тус дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь 2019 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр батлагдсан.<br>Тус дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу аймаг орон нутагт хэрэгжүүлэхээр ИНЕГ-ын төсөвт 580 сая төгрөг төсөвлөгдсөн боловч дэлхий нийтийг хамарсан Covid 19 өвчний тархалтын улмаас Монгол Улсын эдийн засгийн хувьд хүндрэл үүсэх эрсдэлээс сэргийлж ИНЕГ-ын даргын 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/205 тушаалаар батлагдсан Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллуулах тухай тушаалын дагуу 2021 он хүртэл санхүүжилтийг хойшлуулсан.<br>Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх газарзүйн байршлыг тогтоох судалгааг боловсруулж ЗТХЯ болон 21 аймгийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэн.<br>**/Хэрэгжилт 30%/** |
| 2.4. | Хот, суурин газар, суурьшлын бүсэд нийтийн хэрэгцээнд ашиглах вертодром байгуулах | 2.4.1. Хот суурин газар, суурьшлын бүсэд вертодром байгуулах **/ТИНСББХАХТ-8.2/** | Стандарт, норм боловсруулах, батлуулах | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 44 дугаар тушаалаар Аэродром, Хелипортод тавих ерөнхий шаардлага MNS 6784 : 2019 батлагдсан.<br>Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/298 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд 2019 онд батлагдсан хэлипортын стандартын дагуу Улаанбаатар хотод байгуулагдаж буй төр болон хувийн хэвшил, аж ахуй нэгжүүдэд үзлэг шалгалт хийж мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч ажилласан. Үүнд:<br>- Улаанбаатар хотын шинэ захиргааны байгууламжийн ойролцоо байгуулах нисдэг тэрэгний хөөрч буух талбай<br>- Эх хүүхдийн эрүүл мэндийн төвд байгуулагдаж буй талбайд<br>- Гэмтэл согог судлалын үндэсний төвд байгуулагдсан талбайд<br>- International school-д байгуулагдаж буй |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талбайд<br>- Үндэсний олимпын хорооны хажууд байрлах оффисын зориулалттай байригдаж буй байшингийн дээвэр дээр байгуулагдаж буй нисдэг тэрэгний тавцанд тус тус үзлэг шалгалт хийж шаардлагатай заавар, зөвлөгөө өгч ажилласан<br>**/Хэрэгжилт 70%/** |
| | | 2.4.2. Эмнэлэг болон томоохон зочид буудал, барилга, суурьшлын бүсэд вертодром байгуулах<br>**/ЗГҮАХХАХТ-2.115 (2/** | Вертодром байгуулах, ашиглах | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | Хэлипортын стандартын дагуу байгуулагдаж буй нисдэг тэрэгний тавцан<br>1. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв<br>2. Гэмтэл согог судлалын үндэсний төв<br>3. Халдварт өвчин судлалын үндэсний төв<br>4. Алтан булаг чөлөөт бүс<br>5. International school<br>6. Success rider building (дээвэр)<br>7. Сити товер (дээвэр)<br>8. Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг<br>**/Хэрэгжилт 70%/** |
| 2.5. | Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн хөөрч, буух зурвас, вертодром барьж байгуулахад улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төр, хувийн хэвшлийн түншлэл болон хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих | 2.5.1. Орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтаар хөөрч, буух зурвас, вертодром барьж байгуулахад дэмжлэг үзүүлж, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх.<br>**/ЗГҮАХХАХТ-2.115 (2/** | Хувийн вертодром байгуулах, ашиглах боломж бүрдүүлэх | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | Аймаг орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд нийтдээ 17 байршилд бага оврын агаарын хөлөг хөөрч буух зурвас талбайг сонгосон бөгөөд орон нутгийн төсөв хөрөнгөөр байгуулах ажлыг эхлүүлээд байна. Үүнд:<br>- Дархан-Уул аймгийн Дархан хот<br>- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот, Алтанбулаг (чөлөөт бүс)<br>- Баянхонгор аймгийн Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан<br>- Говь-Алтай аймгийн Алтай, Бугат<br>- Хэнтий аймгийн Дадал, Галшар<br>- Сүхбаатар аймгийн Их-Өлгий<br>- Дорнод аймгийн Халхгол, Матад<br>**/Хэрэгжилт 30%/** |
| **Зорилт 3. Ерөнхий зориулалтын нисэхэд ашиглах агаарын зайн зохицуулалт, аюулгүй ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3.1. | Ерөнхий зориулалтын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний үүрэг, хариуцлагыг боловсронгуй болгох | 3.1.1. Иргэний нисэхийн багц дүрэм, холбогдох журамд тусган батлуулах. | Холбогдох зохицуулалтыг тусгах, хэрэгжүүлэх | ИНЕГ | 2018-2022 он | 2018 оны 8 дугаар сарын 17-ны өдөр Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журмын төслийн хэлэлцүүлгийг Иргэний нисэхийн ерөнхий газрын хурлын танхимд зохион байгуулсан бөгөөд тус хэлэлцүүлгээс журам гаргах шаардлагагүй гэж шийдвэр гарсан болович Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Нислэгийн урсгал төлөвлөлтийн албаны мэргэжилтнүүдтэй 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр уулзалт зохион байгуулж "Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журам"-ын төслийг болвсруулж, батлуулах ажлыг яаралтай зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж тус журмын төслийг дахин шинэчлэн боловсруулсан. Уг журмын төсөлд нислэгийн хөдөлгөөний үүрэг, хариуцлагын тухай тодорхой зааж тусгасан. Тус журмын төслийг эцсийн байдлаар боловсруулж дахин дарга нарын зөвлөлд танилцуулсан болович дахин буцаагдсан. ИНҮТ-ийн Агаарын Навигацийн Үйлчилгээний газартай 2020 оны 5 дугаар сарын 12 өдөр уулзалт зохион байгуулсан бөгөөд тус газартай хамтран Америк, Шинэзеланд, Австрали зэрэг улсуудын агаарын зайн бүтэц зохион байгуулалтыг судалж Монгол улсын агаарын зайн зохион байгуулалтыг өөрчлөх санал боловсруулахаар тохиролцсоны дагуу судалгааг боловсруулж эхлээд байна.<br><br>**/Хэрэгжилт 30%/** |
| 3.2. | Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаанд ашиглах агаарын зайн зохицуулалтыг сайжруулах, ашиглалтыг хялбаршуулах | 3.2.1. Иргэний нисэхийн багц дүрэмд нийцүүлэн агаарын зайн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ашиглалтыг хялбаршуулах<br>**/ЗГҮАХХАХТ-2.115. (2)/** | Доод агаарын зайн ашиглалтыг сайжруулах | ИНЕГ | 2018-2022 он | Хяналтгүй агаарын зайн журам болон ерөнхий зориулалтын нисэхийн нислэгийн захиалгыг цахим хэлбэрээр хүлээн авах, хэрэглэгчдэд мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх ажлын хүрээнд агаарын зайн болон шаардлагатай мэдээ мэдээллийг агуулсан цахим хуудас хийгдэж дууссан бөгөөд хүлээж авах комисс байгуулагдан 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүлээн авах комиссын хурлаар шалгаж акт үйлдэн хүлээн авсан. Тус цахим нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.<br>**/Хэрэгжилт 30%/** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3.2.2. Олон улсын болон орон нутгийн нисэх буудалд ерөнхий зориулалтын агаарын хөлгөөр шөнийн, хэрэглэлийн нислэгийн дүрмээр нислэг үйлдэх схем боловсруулах **/ЗГҮАХХАХТ-2.115. (2)/** | Нислэг үйлдэх схем батлуулах, хэрэгжүүлэх | ИНЕГ | 2018-2022 он | Ерөнхий зориулалтын агаарын хөлгүүд ИНД 103.155-ын а.1 заалтаар зөвхөн "Өдрөөр", тус дүрмийн 103.155-ын а.2 болон ИНД 9. Г Бүлгээр "Ил харааны нислэгийн дүрэм"-ээр нислэг үйлдэх тул шөнийн болон хэрэглэлийн нислэгийн дүрмээр нислэг үйлдэх журам зохиох боломжгүй болохыг 2019 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 08/д/115 тоот албан бичгээр мэдэгдсэн. **Үнэлэх боломжгүй** |
| 3.3. | Хяналтгүй агаарын зайн мэдээллийг хэрэглэгчид мэдээлэх тогтолцоог бий болгох, холбогдох баримт бичиг, гарын авлагаар хангах | 3.3.1. Ил харааны нислэгийн газрын зурагт газарзүйн байршил, агаарын зайн ангиллыг тэмдэглэж батлуулах. **/ЗГҮАХХАХТ-2.115. (2)/** | Хэрэглэгчдийг тогтмол мэдээллээр хангах тогтолцоо бий болгох | ИНЕГ | 2018-2022 он | "Ил харааны нислэгийн газрын зураг"-г Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Чикагогийн конвенцын Хавсралт 4-ийн бүлэг 16 "Дэлхийн нислэгийн газрын зураг-ИКАО 1:1,000,000"-д тавигдах шаардлагын дагуу боловсруулсан. **/Хэрэгжилт 70%/** |
| | | 3.3.2. Агаарын зайн мэдээллийг хэрэглэгчид мэдээлэх, холбогдох баримт бичиг, гарын авлагаар хангах тогтолцоог бий болгох **/ЗГҮАХХАХТ-2.115. (2)/** | | ИНЕГ | 2018-2022 он | Хяналтгүй агаарын зайн мэдээллийг хэрэглэгчдэд мэдээлэх шаардлагатай гарын авлага материалаар хангах ажлын хүрээнд олон нийтэд ашиглах, мэдээлэл хүргэх зориулалтаар цахим хуудас боловсруулж дууссан. Тус цахим хуудсанд хэрэглэгчдэд шаардлагатай бүхий л мэдээллийг цаг тухай бүрд шинэчлэн мэдээлж байхаар загварчилсан. **/Хэрэгжилт 30%/** |
| **Зорилт 4. Ерөнхий зориулалтын нисэхийн салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх** | | | | | | |
| 4.1. | Хувийн нисгэч бэлтгэх анхан шатны сургалтын тогтолцоог бүрдүүлж, улмаар ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцэд суурилсан, олон улсын стандарт шаардлага хангасан, бүс нутгийн хэмжээнд сургалт зохион байгуулах хүчин чадал бүхий сургалтын төв байгуулах | 4.1.1. Хувийн нисгэч бэлтгэх анхан шатны сургалтын төв байгуулах тогтолцоо бүрдүүлэх, хэрэгжүүлэх | Сургалтын төв, нисэх клуб 25-ыг байгуулж үйл ажиллагааг тогтворжуулах | ИНЕГ | 2018-2022 он | Буянт-Ухаа дахь нисэх буудлын цаашдын ашиглалтын саналд нисэхийн боловсон хүчин бэлтгэх, сургалтын төв байгуулах саналыг тусгасан. Мөн 2019 оны 08 сарын 29-ний өдөр БНСУ-ын "Алс дорнодын их сургууль"-тай хамтран нисгэгч, инженер зэрэг боловсон хүчин бэлтгэхэд хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Ерөнхий зориулалтын нисэхийн албанаас Буянт-Ухаа дахь нисэх буудлын зохих хэсгийг цаашид бага оврын агаарын хөлгийн засвар үйлчилгээ, нисэхийн сургалтын төв байгуулах тооцоо судалгааг дахин нарийвчлан боловсруулж хэрэгжилтийг эхлүүлэх үүднээс шаардлагатай зай талбайн мэдээллийг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ИНҮТ-ийн Төсөл, хөтөлбөрийн тасагт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлсэн бөгөөд ИНҮТ-ийн Төсөл, хөтөлбөрийн тасгаас "Буянт-Ухаа дахь олон улсын нисэх буудлын цаашдын ашиглалтын төлөвлөгөө"-г нарийвчлан боловсруулж батлуулахаар Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 01/719 тоот албан бичгээр Зам, Тээврийн Хөгжлийн яаманд хүргүүлсэн. Одоогийн байдлаар батлагдаж ирээгүй байна. **/Хэрэгжилт 30%/** |
| | | 4.1.2. Олон улсын стандарт шаардлага хангасан, бүс нутгийн хэмжээнд сургалт зохион байгуулах Сургалтын төв байгуулж, үйл ажиллагааг тогтворжуулах | | | 2018-2022 он | Буянт-Ухаа дахь нисэх буудлын зохих хэсгийг цаашид Ерөнхий зориулалтын нисэхийн төв болгон ашиглах, бага оврын агаарын хөлгийн засвар үйлчилгээ, нисэхийн сургалтын төв байгуулах зэрэг тооцоо судалгааг дахин нарийвчлан боловсруулж хэрэгжилтийг эхлүүлэх үүднээс олон улсын жишигт тохирсон сургалт явуулахад шаардагдах өрөө танхимын хэрэгцээ, сургалтын төвд шаардагдах боловсон хүчний судалгаа, шаардагдах зай талбайн мэдээлэл зэргийг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ИНҮТ-ийн Төсөл, Хөтөлбөрийн тасагт хүргүүлсэн. Одоогийн "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын 3 давхрын зохих хэсгийг ашиглахаар тооцоолол хийсэн болно. **/Хэрэгжилт 30%/** |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.2. | Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн нисэгч, инженер техникийн ажилтныг гадаад, дотоодод бэлтгэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | 4.2.1. Монгол Улсад нисэгч, инженер техникийн ажилтныг бэлтгэх зах зээлийн судалгаа хийх, хэрэгцээ шаардлагыг тогтоож, сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх | Судалгаа хийх, 100-аас доошгүй нисгэгч бэлтгэх | ИНЕГ | 2018-2022 он | Нисэгч, инженер техникийн ажилтан бэлтгэх сургалтын тогтолцоо бүрдүүлэх ажлын хүрээнд Монгол улсын Зам, тээврийн хөгжлийн яам болон БНСУ-ын Алс Дорнын Их сургуультай хамтран байгуулсан санамж бичгийн дагуу Буянт-Ухаа дахь нисэх буудлын дэд бүтцийг тулгуурлан олон улсын нисэхийн сургууль барьж байгуулах тооцоо судалгааг боловсруулсан. Мөн Буянт-Ухаа дахь нисэх буудлын зохих хэсгийг цаашид нисэхийн сургалтын төв болгох тооцоо судалгааг боловсруулж хэрэгжилтийг эхлүүлэх үүднээс шаардлагатай зай талбайн мэдээллийг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр ИНҮТ-ийн Төсөл, хөтөлбөрийн тасагт хүргүүлсэн бөгөөд ИНҮТ-ийн Төсөл, хөтөлбөрийн тасгаас "Буянт-Ухаа дахь олон улсын нисэх буудлын цаашдын ашиглалтын төлөвлөгөө"-г нарийвчлан боловсруулж батлуулахаар Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 01/719 тоот албан бичгээр Зам, Тээврийн Хөгжлийн яаманд хүргүүлсэн. Одоогийн байдлаар батлагдаж ирээгүй байна. Үүсээд буй нөхцөл байдлын улмаас шалтгаалж тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. Тус их 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлэхээр бэлтгэж байсан.<br><br>**/Хэрэгжилт 70%/** |
| 4.3. | Хувийн нисэх клуб, сургалтын байгууллагыг дэмжих | 4.3.1. Иргэний нисэхийн тухай хуулийн хүрээнд нисэх клуб, сургалтын байгууллагад эрх шилжүүлэх, гэрчилгээжүүлэх зохицуулалт бүрдүүлэх | Зохицуулах тогтолцоог бүрдүүлэх | ИНЕГ | 2018-2022 он | ИНД-149 дүрэм шинэчлэн боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 187 тоот тушаалаар батлуулсан.<br>Тус ажлын хүрээнд агаарын хөлөг зээлээр авах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор МУ-ын хөгжлийн банктай 2020 оны 4 дүгээр сарын 8-нд уулзалт зохион байгуулсан бөгөөд цаашид хамтарч ажиллахаар тохиролцоонд хүрсэн. Мөн хувийн хэвшил, аж ахуйн нэгж аэродром байгуулахад газрын татвараас хөнгөлөх тогтолцоо бүрдүүлэх зорилгоор газрын тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулах тандан судалгаа боловсруулсан бөгөөд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлэхээр бэлтгэж байна. **/Хэрэгжилт 0%/** |
| **Зорилт 5. Бага оврын агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар, үйлчилгээний сүлжээг бий болгох** | | | | | | |
| 5.1. | Олон улсын иргэний нисэхийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, өөрийн орны нөхцөлд тохирсон бага оврын агаарын хөлөг угсрах, үйлдвэрлэхэд урт хугацаатай хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх | 5.1.1. Бага оврын агаарын хөлөг угсрах, үйлдвэрлэх чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалт хийх таатай орчинг бий болгох. | Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих | ИНЕГ | 2018-2022 он | Агаарын хөлөг үйлдвэрлэх байгууллагын гэрчилгээжүүлэлт ИНД-148 дүрмийг шинээр боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 187 тоот тушаалаар батлуулсан. Тус дүрмийн хүрээнд бага оврыг агаарын хөлөг угсрах, үйлдвэрлэх чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалт хийх таатай орчин бий болж байна. **/Хэрэгжилт 70%/** |
| | | 5.1.2. Бага оврын агаарын хөлөг түрээсээр болон худалдан авахад агаарын хөлгийг барьцаалан урт хугацааны хөнгөлөлттэй зээл олгох дотоодын эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх | | | 2018-2022 он | МУ-ын Хөгжлийн банкны охин компани болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудад хүү бага, урт хугацаатай санхүүгийн түрээсийн үйлчилгээг үзүүлдэг ДИ БИ ЭМ лизинг компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын захирал холбогдох албан тушаалтнуудтай Ерөнхий зорилалтын агаарын тээвэрлэгчдийн холбоо, хувийн хэвшлийнхэний төлөөллийг оролцуулан хамтарсан уулзалт танилцуулга 2020 оны 4 дүгээр сарын 8-нд зохион байгуулж дэмжлэг авах шийдэлд хүрсэн. Тус санхүүгийн байгууллагатай хамтран Ерөнхий зориулалтын агаарын хөлөг болон энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх хамтарсан тооцоо судалгааг боловсруулж байна. **/Хэрэгжилт 70%/** |
| 5.2. | Бага оврын агаарын хөлөг угсрах, үйлдвэрлэх, туршилт баталгаажуулалт хийх, засвар үйлчилгээний төвүүд байгуулах | 5.2.1. Бага оврын агаарын хөлгийг угсрах, үйлдвэрлэх, туршилт баталгаажуулалт хийх ажлыг ИНБД-ийн хүрээнд дэмжих, гэрчилгээжүүлэх. **/ЗГҮАХХАХТ-2.114. (117)/** | 60-аас доошгүй засвар, үйлчилгээний төв байгуулах, үйл ажиллагааг тогтворжуулах | ИНЕГ | 2018-2022 он | МИАТ ТӨХК-ийн АХЗҮГ-ийг түшиглэн бага оврын агаарын хөлгийг шинэчлэн батлагдсан ИНБД-ийн 148 дугаар дүрмийн хүрээнд угсрах, засварлах, туршин нислэг хийх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Тус дүрмийн хүрээнд Хөдөө аж ахуйн зориулалтаар угсарч байсан ТВС-2МС агаарын хөлөгт тавигдах хөдөлгүүр, сэнс, авионик, моторын рам болон дагалдах сэлбэг хэрэгслийн өртөг 1.4 тэрбум төгрөгийг ИНЕГ-ын өөрийн үйлдвэрлэлийн орлогоос санхүүжих 2019 оны |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсөвт тодотголоор суулгасан ба МИАТ ХК-тай хамтран ажиллах гэрээг 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байгуулж, мөнгийг шилжүүлэхэд бэлэн болгосон. ИНЕГ-ын зүгээс уг агаарын хөлөгт тавигдах хөдөлгүүр, сэнс, авионик, моторын рам болон дагалдах сэлбэг хэрэгсэл худалдан авах санхүүгийн асуудлыг шийдвэрлэх үүргээ бүрэн биелүүлсэн. ОХУ-ын Иргэний нисэхийн байгууллагаас МУ-ын ЗТХЯ-тай уулзалт хийж дээрх сэлбэг хэрэгслийг худалдан авах асуудлыг шийдвэрлэхээр болсон ба олон улсад дэгдээд буй цар тахал дарагдтал уулзалтыг хойшлуулснаар 2020 онд тус агаарын хөлгийг угсарч үйл ажиллагаанд бэлтгэх, гэрчилгээжүүлэх ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. **/үнэлэх боломжгүй/** |
| 5.3. | Томоохон хот, суурин газар, орон нутагт ерөнхий зориулалтын агаарын хөлгийн засвар, үйлчилгээний төв байгуулахыг дэмжиж, сүлжээ бий болгох | 5.3.1. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн засвар үйлчилгээний төв байгуулахыг ИНБД-ийн хүрээнд дэмжих, гэрчилгээжүүлэх. **/ЗГҮАХХАХТ-2.114. (117)/** | | | 2018-2022 он | Агаарын хөлгийн засвар үйлчилгээний төв байгуулах ажил ИНД-21 дүрэмд тусгагдаж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 187 дугаар тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан. Тус дүрмийн хүрээнд "Тэнгэрийн Улаач шинэ" ХХК Буянт Ухаа дахь нисэх буудлын бүсэд шинээр бага оврын агаарын хөлгийн засвар үйлчилгээний төв байгуулж байна.<br>Дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэсний дараагаар үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд үүсээд буй нөхцөл байдлын улмаас удаашралтай байна. **/үнэлэх боломжгүй/** |
| 5.4. | Агаарын хөлгийн сэлбэг, тоног төхөөрөмжийн хангамж, үйлчилгээний сүлжээ бий болгох | 5.4.1. Агаарын хөлгийн сэлбэг, тоног төхөөрөмжийн хангамж, үйлчилгээний сүлжээ бий болгох эрх зүйн зохицуулалт бүрдүүлэх | Эрх зүйн зохицуулалтыг бүрдэж хэрэгжих | ИНЕГ | 2018-2022 он | Гаалийн тариф татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай санал хүргүүлсэн бөгөөд "Гаалийн тариф, гаалийн татварын тухай" хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9.-д Иргэний агаарын бүх хөлөг болон хөдөлгүүр, тэдгээрийн бүх эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, 38.1.9.-д газар дээрх нислэгийн бүх дадлагажуур болон түүний эд анги, бүрэлдэхүүн хэсэг гэж тусгагдсан.<br><br>2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн Пипистрел компаниас ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээний төлөвлөгөөний 5.1.1 дэх, 5.1.2. дахь, 5.2.1. дэх, 5.3.1.дэх, 5.4.1. дэх зорилтуудыг тус тус хэрэгжүүлэхээр Бүгд Найрамдах Словени Улсын Пипистрел компанитай уулзалт зохион байгуулах, Монгол Улсад Пипистрел агаарын хөлгийг угсрах, гадаад орнуудад экспортлох, сэлбэг хэрэгслийг нийлүүлэх талаар тус компаниас ирүүлсэн саналын хүрээнд уулзалтад оролцож, цаашдын хамтын ажиллагааг эхлүүлэхээр тохиролцоонд хүрсэн.<br>Гаалийн тариф татварын тухай хуульд Агаарын хөлгийн сэлбэг тоног төхөөрөмж Монгол улсын хэлээр орж ирхэд татварын хөнгөлөлт үзүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан 2019 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн 01/856 албан тоотоор ЗТХЯ-нд хүргүүлсэн.<br>**/Хэрэгжилт 30%/** |
| **Зорилт 6. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээг бий болгох** | | | | | | |
| 6.1. | Ерөнхий зориулалтын агаарын хөлөгт ашиглах авгаз болон бусад төрлийн шатахууныг олон эх үүсвэрээс нийлүүлэх боломж бүрдүүлэх | 6.1.1. Ерөнхий зориулалтын агаарын хөлөгт хэрэглэгдэх шатахуунд тавигдах норм, стандартыг тогтоох | Норм, стандарт батлах, хэрэгжүүлэх | ИНЕГ | 2018-2021 он | Агаарын хөлгийн шатахууны стандарт MNS 0217:2017 болон Тийрэлтэт хөдөлгүүрийн түлш ТС-1 түлш нь техникийн шаардлагын MNS 5677: 2006 Олон Улсын стандарт шаардлагын дагуу мөрдөгддөг. Иймд норм, стандарт дахин батлуулах шаардлагагүй гэж үзсэн.<br>**/үнэлэх боломжгүй/** |
| 6.2. | Томоохон хот, суурин газар, орон нутагт ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээ байгуулахыг дэмжих | 6.2.1. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээ байгуулах, нийлүүлэх эх үүсвэр, хилийн боомтыг тогтоох судалгаа хийх **/ЗГҮАХХАХТ-2.17.3/** | Судалгаа хийх, хэрэгжүүлэх | ИНЕГ | 2018-2022 он | Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээ байгуулах газарзүйн байршлыг тогтоох, нийлүүлэх эх үүсвэр хилийн боомтыг тогтоох судалгааг хийж удирдлагад танилцуулсан бөгөөд судалгаанаас гарсан санал дүгнэлтийг 2019 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 02/3273 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.<br>**/Хэрэгжилт 0%/** |
| | | 6.2.2. Аймаг, нийслэл, сумдын хэрэглээнд үндэслэн агаарын хөлгийн шатахуун хангамжийн төв, агуулахын оновчтой сүлжээг бий болгох **/ЗГҮАХХАХТ-2.17.3/** | 30-аас доошгүй байршилд шатахуун хангамжийн төв байгуулах | ИНЕГ | 2018-2022 он | ИНЕГ-ын 2020 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд 12 төв байгуулах төсвийн санал оруулсан. Тус ажлын хүрээнд 2020 онд өртөөчилсөн байдлаар Булган аймгийн нисэх буудал болон Хөвсгөл аймгийн нисэх буудлуудад бага оврын агаарын хөлөгт өргөн хэрэглэгддэг Авгаз шатахуун түгээх төв байгуулахаар ИНЕГ-ын төсөвт 240 төгрөг төсөвлөсөн боловч үүсээд буй нөхцөл байдлын улмаас хэмнэлтийн горимд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шилжсэний дагуу түр хойшлуулах шийдвэр гарсан. 2020 онд байгуулах боломжгүй болсон. **/үнэлэх боломжгүй/** |
| **Зорилт 7. Иргэд хувийн хэрэгцээндээ агаарын хөлөг ашиглахыг дэмжин хөгжүүлэх** | | | | | | |
| 7.1. | Иргэний хувийн хэрэгцээнд ашиглах бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэгт тавигдах стандарт, шаардлагыг тогтоож, холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгох | 7.1.1. Хувийн хэрэгцээнд ашиглах бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэгт тавигдах стандарт, шаардлагыг тогтоох судалгаа хийх | Стандарт батлах, хэрэгжүүлэх | ЗТХЯ ИНЕГ | 2018-2022 он | Манай улсад бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэгт тавигдах стандарт, шаардлагыг ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ – 21-р дүрмээр болон АНУ-ын Холбооны нисэхийн алба /FAA/-наас гаргасан дараах дүрмийг хүлээн зөвшөөрнө.<br><br>1.1. агаарын хөлөгт: - Part 23 Airworthiness Standards: Normal, Utility and Acrobatic Category Airplanes (тус дүрмийн 23.785(a) болон 23.807(b)(5)-аас бусад); Airworthiness Standards: Transport Category Airplanes; - Part 27 Airworthiness Standards: Normal Category Rotorcraft; - Part 29 Airworthiness Standards: Transport Category Rotorcraft.<br>1.2. агаарын хөлгийн хөдөлгүүр сэнсэнд: - Part 33 Airworthiness Standards: Aircraft Engines; - Part 35 Airworthiness Standards: Propellers.<br>2.1. Чикагогийн конвенцийн Хавсралт 8-ыг хангасан; болон 2010 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс хойш Чикагогийн конвенцийн Хавсралт 16-д тодорхойлсон дараах шаардлагуудыг дагаж мөрдөнө:<br><br>1.1. Тийрэлтэт хөдөлгүүрээр тоноглогдсон онгоцнууд нь Нэгдүгээр дэвтрийн II-р хэсгийн бүлэг 3 болон 4-ийн холбогдох стандартуудыг;<br>1.2. сэнст хөдөлгүүрээр тоноглогдсон онгоцнууд нь Нэгдүгээр дэвтрийн II хэсгийн бүлэг 3, 4, 5, 6 болон 10-ын холбогдох стандартуудыг;<br>1.3. нисдэг тэрэгний хувьд Нэгдүгээр дэвтрийн II хэсгийн бүлэг 8 болон 11-ийн холбогдох стандартуудыг; |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн Чикагогийн конвенцийн Хавсралт 16-ийн Хоёрдугаар дэвтэрт тодорхойлсон шаардлагуудыг дагаж мөрдөнө; эсхүл ИНЕГ-ын даргын хүлээн зөвшөөрсөн адилтгах хэмжээний загварын НТЧ-ын стандартыг мөрдөнө.<br><br>Дээрх АНУ-ын Холбооны нисэхийн алба /FAA/-наас гаргасан дүрмүүд болон Чикагогийн конвенцийн Хавсралт 8, Чикагогийн конвенцийн Хавсралт 16-ийн Нэгдүгээр дэвтрийн II хэсгийн бүлэг 3, 4, 5, 6 болон 10-ын холбогдох стандартуудыг; нисдэг тэрэгний хувьд Нэгдүгээр дэвтрийн II хэсгийн бүлэг 8 болон 11-ийн холбогдох стандартуудыг судлан орчуулж удирдлагад танилцуулан Зам, тээврийн хөгжлийн яаманд 2019 оны 09 дүгээр сарын 27-ны 02/3273 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Иймд дээрх стандарт нь ИНД-21-р дүрэмд нарийвчлан заасан байдаг тул батлуулах шаардлагагүй гэж үзсэн. **/үнэлэх боломжгүй/** |
| | | 7.1.2. Хувийн хэрэгцээнд бага оврын агаарын хөлөг, нисдэг тэрэг ашиглах, эйр такси болон бусад бүтээгдэхүүн, үйлчилгээ гүйцэтгэх эрх зүйн зохицуулалт бүрдүүлэх | Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих | | 2018-2022 он | Чикагогийн конвенцийн Хавсралт 8, 16-ын part 1, part 2-ийн Монгол улсад хамаарч болох хэсгүүдийг орчуулж эрх зүйн баримт боловсруулах ажлыг эхлүүлээд байна. **/Хэрэгжилт 0%/** |
| | | 7.1.3. Агаарын хөлөг худалдан авах, түрээслэхэд урт хугацаатай хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар судалгаа хийх, шийдвэрлэх. | Судалгаа хийх, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох | | 2018-2022 он | МУ-ын Хөгжлийн банкны охин компани болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудад хүү бага, урт хугацаатай санхүүгийн түрээсийн үйлчилгээг үзүүлдэг ДИ БИ ЭМ лизинг компанийн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын захирал холбогдох албан тушаалтнуудтай Ерөнхий зорилалтын агаарын тээвэрлэгчдийн холбоо, хувийн хэвшлийнхэний төлөөллийг оролцуулан хамтарсан уулзалт танилцуулга 2020 оны 4 дүгээр сарын 8-нд зохион байгуулж дэмжлэг авах шийдэлд хүрсэн. Тус санхүүгийн байгууллагатай хамтран Ерөнхий зориулалтын агаарын хөлөг болон энэ чиглэлээр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйл ажиллагаа эрхлэгч байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх хамтарсан тооцоо судалгааг боловсруулж байна. **/Хэрэгжилт 70%/** |
| 7.2. | Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийн холбоо, навигацийн төхөөрөмжийн шаардлагыг боломжит хамгийн бага төвшинд байлгах зохицуулалтыг хийх | 7.2.1. Холбогдох зохицуулалтыг “Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журам”-д тусгах, хэрэгжүүлэх | Эрх зүйн зохицуулалт бүрдэж хэрэгжих | ИНЕГ | 2018-2022 он | Ерөнхий зориулалтын агаарын хөлөгт өргөн ашиглагддаг агаарын хөлгийн холбоо, навигацийн төхөөрөмжийн судалгаа боловсруулж удирдлагад танилцуулсан. Агаарын зайн мэдээллийн цахим хуудсаар дамжуулан хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэж буй бага оврын агаарын хөлгийн байршлыг газрын зурагт шууд үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Тус ажил биеллээ олсон тохиолдолд Ерөнхий зориулалтын нислэг үйлдэж буй агаарын хөлгүүд маш бага зардлаар навигацийн асуудлыг шийдвэрлэх бүрэн боломжтой болно. **/Хэрэгжилт 30%/** |
| | | 7.2.2. Агаарын хөлгийн тракинг систем, зөөврийн ELT зэрэг төхөөрөмжийг өргөн ашиглах, импортлох, энэ чиглэлээр дотоодын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх | | | 2018-2022 он | Тракинг систем, зөөврийн ELT зэрэг төхөөрөмжийг өргөн ашиглах, импортлох, энэ чиглэлээр дотоодын, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах төсөл боловсруулан удирдлагад танилцуулсан бөгөөд нэмэлт тодруулах шаардлагатай зүйлсийг нэмэн дэлгэрүүлж судалгааг дахин боловсруулж байна. **/Хэрэгжилт 70%/** |

2018-2022 ОНД ХЭРЭГЖИХ “ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЭХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР”-ИЙН

ХЭРЭГЖИЛТ 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР **50,6** ХУВЬ (%)-ТАЙ БАЙНА.

ТАНИЛЦСАН:
ИНҮТ-ИЙН НБҮГ-ЫН ДАРГА Д.МЯГМАРСҮРЭН

ХЯНАСАН:
ИНҮТ-ИЙН НБҮГ-ЫН ОРОН НУТАГ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР Э.ЭНХЗОРИГ

БОЛОВСРУУЛСАН:
ЕЗНА-НЫ МЭРГЭЖИЛТЭН Б.ЖАРГАЛ